МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Улаанбаатар хот

2015 оны 6 дугаар сар

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Газрын дарга, тэргүүлэх аудитор

М.Наранжаргал

Аудитын менежер

Д.Баттулга
Г.Гүнжидмаа
Л.Эрдэнэчулуун

Ахлах аудитор

Д.Гандолгор
С.Сэрчхорол
Ж.Эрдэнэ
Р.Гончигцэрэн
Ц.Сугармаа
Ц.Гэрэл
Д.Цэрэндорж

Аудитор

Ж.Оюунтуяа
Э.Уянга
М.Туул
Б.Нямхүү
Ш.Наранбаатар
Б.Ариунжаргал
Г.Мөнхчимэг
Х.Энх-Амгалан

Зөвлөх ***Г.Нямдорж***

2014 оны 6 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү:

www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261456 дугаарын утсаар харилцана уу.

ХАЯГ: Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3 Улаанбаатар-15160 Монгол Улс

АГУУЛГА

	Товчилсон үгийн жагсаалт	**2**
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
	БҮЛЭГ 1 МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ	**4**
1.1	Нэгдсэн төсвийн орлого	4
1.2	Нэгдсэн төсвийн зарлага	7
1.3	Монгол Улсын Засгийн газрын 2014 оны өр	7
1.4	Нэгдсэн төсвийн тэнцэл	11
	БҮЛЭГ 2 МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ ТӨСӨВ	**11**
2.1	Улсын төсвийн орлого	11
2.2	Улсын төсвийн зарлага	15
2.3	Улсын төсвийн тэнцэл	17
	БҮЛЭГ 3 ОРОН НУТГИЙН 2014 ОНЫ ТӨСӨВ	**18**
3.1	Орон нутгийн төсвийн орлого	18
3.2	Орон нутгийн зарлага	20
3.3	Орон нутгийн төсвийн тэнцэл	21
	БҮЛЭГ 4 ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2014 ОНЫ ТӨСӨВ	**22**
4.1	Хүний хөгжил сангийн төсвийн орлого	22
4.2	Хүний хөгжил сангийн төсвийн зарлага	22
4.3	Хүний хөгжил сангийн төсвийн тэнцэл	23
	БҮЛЭГ 5 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2014 ОНЫ ТӨСӨВ	**24**
5.1	Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого	24
5.2	Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарлага	24
5.3	Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл	25
	БҮЛЭГ 6 НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	**26**
	БҮЛЭГ 7 ДҮГНЭЛТ	**27**
	БҮЛЭГ 8 ЗӨВЛӨМЖ	**28**
	ХАВСРАЛТ	**29-31**
	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ	**32**

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ		Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ		Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АҮЯ		Аж үйлдвэрийн яам
АТБӨЯХ		Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
БНХАУ		Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОНХАЖС		Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд
БХБС		Барилга, хот байгуулалтын сайд
БСШУС		Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БХЯ		Батлан хамгаалах яам
ГХС		Гадаад хэргийн сайд
ДНБ		Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС		Дулааны цахилгаан станц
ЗГ		Засгийн газар
ЗДТГ		Засаг даргын тамгын газар
ЗТС		Зам тээврийн сайд
ЗТЯ		Зам тээврийн яам
ЖДҮДС		Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ИТХ		Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНЕГ		Иргэний нисэхийн ерөнхий газар
НДС		Нийгмийн даатгалын сан
НӨАТ		Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ		Нийгмийн даатгалын шимтгэл
ӨННАТ		Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр
СЯ		Сангийн яам
ТЕЗ		Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХК		Төрийн өмчит хувьцаат компани
ТЕЗ		Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ		Улсын Их Хурал
УЕП		Улсын Ерөнхий Прокурор
ҮҮГ		Улсын үйлдвэрийн газар
ҮАГ		Үндэсний аудитын газар
ҮОМШӨ		Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХС		Хөдөлмөрийн сайд
ХХААС		Хүнс, хөдөө аж ахуйн сайд
ХАХНХС		Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд
ХЗС		Хууль зүйн сайд
ХХС		Хүний хөгжил сан
ХХОАТ		Хувь хүний орлогын албан татвар
ХНН		Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХХК		Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШС		Шадар сайд
ШЕЗ		Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭМСЯ		Эрүүл мэнд, спортын яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газар Төсвийн тухай хуулийн 8.10.2[1] дугаар заалтын дагуу Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд 2015 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдрийн хооронд аудит хийв.

Аудитын зорилт

Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 12.1.7[2] дугаар заалтын дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны гүйцэтгэлийн тайлан, танилцуулгыг дараах бүрэлдэхүүн хэсэг, дараалалтай тайлагнажээ. Үүнд:

- Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл
- Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл
- Хүний хөгжил сангийн төсвийн 2014 оны гүйцэтгэл
- Нийгмийн даатгалын сангийн төсвийн 2014 оны гүйцэтгэл
- Орон нутгийн төсвийн 2014 оны гүйцэтгэл
- Монгол Улсын Засгийн газрын өрийн талаарх танилцуулга

Танилцуулгын хавсралт мэдээлэлд:

- Чингис бондын эх үүсвэрээс 2014 онд олгосон санхүүжилтийн мэдээ
- Төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжиж буй төслүүдийн гүйцэтгэл
- Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, үр дүнгийн үзүүлэлт
- Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл, үр дүнгийн үзүүлэлт
- Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцлийн тухай
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт
- Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэл
- 2014 оны нэмэлт төсвийн зарлагын гүйцэтгэлийн тайланг тус тус харуулсан байна.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхдээ аудитын олон улсын стандарт, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгосны зэрэгцээ холбогдох яам, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайланд орон нутгийн төсвийн гүйцэтгэлд нэгдсэн удирдамжаар аудит хийж нэгтгэлээ. Түүнчлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусад нь аудит хийсэн тул нэгдсэн төсвийн тайланд оруулаагүй болно.

Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

[1] *"төрийн аудитын тов байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлэх"*
[2] *"нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах*

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ

1.1 Нэгдсэн төсвийн орлого

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаас орох татварын орлогыг 1,073.6 тэрбум төгрөг байхаар зэс, коксжих болон боловсруулсан чулуун нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг хүснэгтэд үзүүлснээр тооцжээ.

(үнийн дундаж, тонн ам.долларoор)

Зэс	6,241.9
Боловсруулсан нүүрс	131.5
Коксжих нүүрс (ккал 5500-с дээш)	80.2
Чулуун нүүрс (4000-5500ккал)	65.5

2014 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцүүлж, 2013 оны гүйцэтгэлээс 14 хувиар нэмэгдүүлэн 6,883.9 тэрбум төгрөгт хүрэхээр тооцоолсон байна.

2014 онд Оюутолгой ХХК 723.1 мянган тонн зэсийн баяжмал, 24.9 тонн алт, 43.6 тонн мөнгө олборлож улсын төсөвт оруулах орлогыг 2013 оны гүйцэтгэлээс 74.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 286.6 тэрбум төгрөг байхаар тооцжээ.

УИХ 2014 онд Улсын төсөвт 2 удаа тодотгол хийж орлогыг 60.7 тэрбум, зарлагыг 58.9 тэрбум төгрөгөөр өсгөж нэгдсэн төсвийн орлого 7,033.3 тэрбум, зарлага 7,640.4 тэрбум төгрөг болсон байна.

Нэгдсэн төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна

2014 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн гүйцэтгэлээр 6,316.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөө 716.8 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна. Хүснэгтээр харуулбал:

/тэрбум төгрөг/

Төсвийн орлогын ангилал, зүйл	Нэгдсэн төсөв			
	Төл	Гүйц	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**7,033.3**	**6,316.5**	**-716.8**	**89.8**
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	**29.8**	**39.9**	**10.1**	**133.9**
1. ХХС – АМНАТ	16.7	14.3	-2.3	85.6
2. ХХС – Өсөн нэмэгдэх нөөцийн төлбөр	13.1	25.6	12.5	195.4
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**7,003.5**	**6,276.6**	**-726.9**	**89.6**
А. УРСГАЛ ОРЛОГО	**7,001.3**	**6,274.3**	**-727.0**	**89.6**
I. ТАТВАРЫН ОРЛОГО	**6,201.4**	**5,157.0**	**-1,044.4**	**83.2**
1. Орлогын албан татвар	1,244.4	1,101.0	-143.4	88.5
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1,084.3	917.6	-166.7	84.6
3. Өмчийн татвар	50.2	50.1	-0.1	99.8
4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,702.4	1,371.7	-330.7	80.6
5. Онцгой албан татвар	597.7	454.4	-143.3	76.0
6. Тусгай зориулалтын орлого	40.1	39.9	-0.2	99.5
7. Гаалийн албан татвар	426.2	355.3	-70.9	83.4
8. Бусад татвар (төлбөр, хураамж)	1,055.9	867.0	-188.9	82.1
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	**799.9**	**1,117.4**	**317.5**	**139.7**
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	**2.2**	**2.3**	**0.1**	**104.5**
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	**0**	**0**	**0**	**0**

Эх сурвалж: Сангийн яамны мэдээллээс авав.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 82.2 хувь татварын, 17.8 хувь татварын бус болон хөрөнгийн орлогоос тус тус бүрдэж байгаа ба татварын орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээг харуулбал:

ҮЗҮҮЛЭЛТ	2010	2011	2012	2013	2014
ДНБ, оны үнээр */тбм.төг/*	8,414.5	10,829.6	14,012.0	17,550.2	21,937.2
Татварын орлого	2,688.2	3,668.3	4,203.3	5,072.8	5,157.0
Татварын ачаалал, %	31.9	33.8	29.9	28.9	23.5

Хүснэгтээс харахад 2014 онд ДНБ-ий хэмжээ 2010 оноос 13.5, өмнөх оноос 4.4 их наяд төгрөгөөр өсч, харин ДНБ-д эзлэх татварын ачаалал 23.5 хувьтай байгаа нь 2010 оныхоос 8.4, 2013 оныхоос 5.4 пунктээр тус тус буурчээ.

Манай улсын төсвийн орлогын 20 орчим хувийг эзэлдэг зэсийн баяжмал, нүүрс, цайрын баяжмал, төмрийн хүдэр, жонш зэрэг эрдэс бүтээгдэхүүний экспортын орлого сүүлийн 5 жилд 29-өөс 18 хувь хүртэл 11 пунктээр буурсан байна.

Эх сурвалж: Сангийн яамны тооцоололд суурилав.

Уул уурхайн салбараас 2014 онд нийт 1,424.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч нүүрс, төмрийн хүдрийн үнийн бууралтаас шалтгаалан 1,112.8 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрч дээрх орлогын 60.4 хувь буюу 672.0 тэрбум төгрөгийг зэс, 25.4 хувь буюу 282.2 тэрбум төгрөгийг нүүрсний орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн хүрээний мэдэгдлийн зарим шалгуур үзүүлэлт хангагдаагүй байна

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан шалгуураас ДНБ-нд эзлэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тэнцэл, өрийн үзүүлэлт хангагдаагүй байна.

2014 оны төсвийн хүрээний мэдэгдлийн шалгуур үзүүлэлт, гүйцэтгэлийг харуулбал:

№	*Шалгуур үзүүлэлт*	*2014*	
		хүрэх түвшин	***хүрсэн түвшин***
1	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого хэмжээ */тбм.төг/*	6,903.8	6,276.6
	▸ ***ДНБ-д эзлэх хувь***	***33.7***	***28.6***
2	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ */тбм.төг/*	7,313.8	7144..6
	▸ ***ДНБ-д эзлэх хувь***	***35.7***	***32.6***
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл */тбм.төг/*	(410.0)	(867.9)
	▸ ***ДНБ-д эзлэх хувь***	***(2.0)***	***(3.9)***
4	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тбм.төг/	2,006.4	1,771.1
	▸ ***ДНБ-д эзлэх хувь***	***9.8***	***8.1***
5	Улсын өрийн нийт хэмжээ өнөөгийн үнэ цэнээр */тбм.төг/*	8,201.2	11,871.6
	▸ ***ДНБ-д эзлэх хувь***	***40.0***	***54.1***
6	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжих зардлын нийт хэмжээ */тбм.төг/*	266.8	212.3
	▸ ***ДНБ-д эзлэх хувь***	***1.3***	***1.0***

2014 оны төсвийн хүрээний мэдэгдэлд ДНБ-ий бодит өсөлт 11.2 хувь байхаар тооцсон ч гүйцэтгэлээр 7.4 хувь буюу 3.8 пунктээр бага гарчээ.

Тайлант онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларснаас гадаад валютаар тооцсон өрийн үлдэгдлийн төгрөгөөр илэрхийлэгдсэн хэмжээ нэмэгдсэн, төсвийн орлого тасарсан нь төсвийн хүрээний мэдэгдлийн шалгуур үзүүлэлтийн биелэлтэд сөргөөр нөлөөлсөн байна.

Тогтворжуулалтын сангийн орлогын төлөвлөгөө 33.9 хувиар давж биелэхэд зэсийн үнийн өсөлт нөлөөлжээ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3[3]-д заасны дагуу тооцсон гол нэр төрлийн эрдэс баялаг зэс, нүүрсний 2014 оны тэнцвэржүүлсэн үнийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал,

Бүтээгдэхүүний төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Зэс	6,241.97	6,859.20	617.23
Баяжуулсан нүүрс	115.90	71.90	(44.00)
Боловсруулаагүй нүүрс	81.60	43.40	(38.20)

Тайлбар: 1тн-ыг ам.долларoор тооцсон дүнгээр

Тогтворжуулалтын санд эрдэс баялгийн зах зээлийн үнэ болон тэнцвэржүүлсэн үнийн зөрүүгээс нийт 29.8 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулахаар тооцсоноос 39.9 тэрбум төгрөг төвлөрсөнд зэсийн зах зээлийн жилийн дундаж үнэ тэнцвэржүүлсэн үнээс 9.7 хувиар өндөр байсан нь эерэгээр нөлөөлж, харин нүүрсний зах зээлийн үнэ тайлант оны турш тэнцвэржүүлсэн үнээс доогуур түвшинд байснаас орлого төвлөрөөгүй байна.





Эх сурвалж: Сангийн яамны тооцоололд суурилав.

"Төсвийн тогтворжуулалтын сангийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2014 оны 396 дугаар тогтоол[4]-ын дагуу Монгол Улсын 2014 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүүг нөхөх зорилгоор Төсвийн тогтворжуулсан сангийн хуримтлагдсан хөрөнгөөс 118.2 тэрбум төгрөгийг улсын төсвийн орлогод шилжүүлж, тус сангийн хуримтлал тайлант оны эцэст 304.2 тэрбум төгрөгт хүрчээ.



[3] *дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд болон жилийн төсвийн төсөлд тусгах гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг арга члалаар тодорхойлж байх*

[4] *Монгол Улсын 2014 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө, төсвийн орлогын гүйцэтгэлийн зөрүүг нөхөх зорилгоор Төсвийн тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан хөрөнгөөс 118.2 тэрбум төгрөгийг улсын төсвийн орлогод шилжүүлэн зарцуулахыг Сангийн сайдад зөвшөөрсөн байна.*

1.2 Нэгдсэн төсвийн зарлага

Нэгдсэн төсвийн зарлага 2014 онд 7,640.4 тэрбум төгрөгөөр батлагдаж 7,144.6 тэрбум төгрөгийн буюу 93.5 хувийн гүйцэтгэлтэй ба эдийн засгийн ангиллаар харуулбал:

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Нэгдсэн		Улсын		Орон нутгийн		ХХС		НДС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	**7,640.4**	**7,144.6**	**5,631.4**	**5,229.2**	**2,375.1**	**2,129.6**	**318.5**	**312.5**	**1,310.3**	**1,315.0**
Урсгал зарлага	5,517.2	5,293.4	4,231.9	3,910.2	1,670.1	1,606.6	313.1	312.5	1,296.9	1,305.8
Хөрөнгийн зардал	2,123.7	1,771.1	1,399.9	1,238.8	704.9	522.9	5.4	0	13.4	9.3
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-0.5	80.1	-0.5	80.1	0	0	0	0	0	0

Хүснэгтээс харахад нийт зарлагын 58.2 хувийг улсын, 23.6 хувийг орон нутгийн, 14.7 хувийг НДС-гийн, 3.5 хувийг ХХС-гийн төсөв, нийт зарлагын 74.1 хувийг урсгал зардал, 25.1 хувийг хөрөнгийн зардал, 0.8 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл тус тус эзэлж байна.

1.3 Монгол Улсын 2014 оны өр

Монгол Улсын гадаад өрийн төгрөгөөр илэрхийлэгдсэн хэмжээ валютын ханшийн өсөлтөөр нэмэгдсэн байна

Монгол Улсын гадаад өрийн бүтэц нь гадаад зээл болон үнэт цаас, өрийн баталгаанаас бүрдэж байна.

Гадаад зээл Монгол Улсын Засгийн газар тайлант онд хандивлагч орон, Олон улсын санхүүгийн байгууллагаас нийт 202.9 сая ам.доллар буюу 369.0 тэрбум төгрөгийн гадаад зээлийг авч ашиглан, гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт 144.9 сая ам.доллар буюу 267.1 тэрбум төгрөг, үүнээс 226.4 тэрбум төгрөгийг үндсэн төлбөрт, 40.7 тэрбум төгрөгийг хүүний төлбөрт төлж, гадаад зээлийн үлдэгдэл 2014 оны жилийн эцсийн байдлаар 2,110.3 сая ам.доллар буюу 3,979.1 тэрбум төгрөг байна.

Тайлант онд авч ашигласан нийт зээлийн 58.8 хувь Зам, тээврийн сайдад, 17.2 хувь Барилга хот байгуулалтын сайдад ногдож байгаа ба ТЕЗ-дын авч ашигласан зээлийн хэмжээг харуулбал,

/тэрбум төгрөг/

Төсвийн ерөнийлөн захирагч	***Ашиглалт***	***Нийт зээлд эзлэх хувь***
Монгол Улсын Ерөнхий Сайд	15.8	4.3
Улсын Их Хурал	0.9	0.2
Сангийн сайд	18.4	5.0
Барилга, хот байгуулалтын сайд	63.3	17.2
Боловсрол, шинжлэх ухааны сайд	2.3	0.6
Зам тээврийн сайд	216.9	58.8
Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд	3.2	0.9
Эрүүл мэнд, спортын сайд	11.5	3.1
Эрчим хүчний сайд	17.1	4.6
Хүнс, хөдөө аж ахуйн сайд	3.7	1.0
Орон нутгийн засаг захиргаа	15.9	4.3
ТЕЗ-дын авч ашигласан гадаад зээлийн дүн	**369.0**	**100.0**

Гадаад үнэт цаас УИХ-ын 2012 оны 52 дугаар тогтоолын дагуу арилжаалсан 1,500.0 сая ам.долларын /Чингис/ бондын хүүгийн төлбөрт тайлант онд 71.9 сая ам.доллар буюу 130.7

тэрбум төгрөгийн төлбөр хийгдэж, 2014 оны 12 дугаар сарын 31-нээрх нэрлэсэн үлдэгдэл 2,828.4 тэрбум төгрөг байна.

Өрийн баталгаа Засгийн газрын өрийн баталгаа тайлант оны эцэст 2,544.4 тэрбум төгрөг байгаа ба үүнээс Хөгжлийн банкны үнэт цаасны үлдэгдэл 580.0 сая ам.доллар буюу 1,066.8 тэрбум, Хөгжлийн банкны Самурай бондын 30.0 тэрбум иен, БНХАУ-ын Хөгжлийн банкнаас авсан 112.0 сая ам.долларын зээл, Кредит Свисс банкны 300.0 сая ам.долларын зээл, "МИАТ" ТӨХК-нд гаргасан баталгаа зэрэг байна.

Монгол Улсын гадаад зээл, үнэт цаасны үлдэгдлийг харуулбал:

/тэрбум төгрөг/

Гадаад зээлийн ангилал	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Хувь
Хөтөлбөрийн зээл	74.69	0.00	0.00	3.52	78.21	2.0%
Төслийн зээл	2,523.13	352.64	75.60	157.62	2,957.79	74.3%
Автозамын зээл	316.40	8.99	16.27	21.66	330.78	8.3%
Санхүүгийн зээл	589.35	7.40	22.71	33.09	607.14	15.3%
ОУВС зээл	107.75	0.00	109.95	7.43	5.23	0.1%
Хугацаа хэтэрсэн өрийн шийдвэрлэлт	1.73	0.00	1.86	0.13	0.00	0.0%
Нийт гадаад зээл	**3,613.05**	**369.03**	**226.38**	**223.44**	**3,979.15**	**58.5%**
Чингис бонд	2,481.15	0.00	0.00	347.25	2,828.40	41.5%
Нийт дүн	**6,094.20**	**369.03**	**226.38**	**570.69**	**6,807.55**	**100.0%**

Засгийн газрын гадаад валютаар илэрхийлэгдэх өрийн багцад ам.доллар 50.2 хувийг, зээлжих тусгай эрх 29.9 хувийг, иен 12.3 хувийг, евро 4.3 хувийг, бусад валют 3.3 хувийг тус тус эзэлдэг ба 2014 оны төсөвт 1 ам.долларын ханшийг 1384 төгрөгөөр тооцоолсон боловч төгрөгийн ханш оны эхнээс дунджаар 10-15 хүртэл хувиар суларснаас гадаад зээлийн төлбөрийн хэмжээ өссөн байна.

Монгол Улсын гадаад улс орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан зээлийн 29.3 хувийг зам, тээврийн салбарт, 12.7 хувийг санхүүгийн болон эрчим хүчний салбарт, 9.4 хувийг орон сууц, нийтийн аж, ахуйн салбарт ашиглаж байна.

Хуулиар зөвшөөрсөн хэмжээнд үнэт цаасыг арилжаалсан байна

Дотоод үнэт цаас Засгийн газраас төсвийн болон Хүний хөгжил сангийн улирлын шинж чанартай орлогын дутагдал, төсвийн алдагдал, өрийг дахин санхүүжүүлэх, зарим зорилтот хөтөлбөр, үйл ажиллагааг дэмжих зорилгоор Төсвийн тухай хуулиар баталгаажсан нийт 2,588.7 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий үнэт цаасыг тайлант онд арилжаалсан ба тайлант онд 927.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг буцаан төлж, жилийн эцсийн үлдэгдлээр 2,964.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2014 оны Төсвийн тухай хуулийн 9.1[5]-д заасны дагуу арилжаалсан Засгийн газрын он дамжих нөхцөлтэй үнэт цаасны дүн 1,391.8 тэрбум төгрөг байгаа ба тайлант онд үнэт цаасны үндсэн төлбөрт нийт 1,380.2 тэрбум төгрөгийг төлжээ. Үүнд:

- Төрийн албан хаагч болон иргэдийг орон сууцны урт хугацаат зээлийн эх үүсвэрээр хангах "4000 айлын орон сууц хөтөлбөр"-ийн хүрээнд гаргасан үнэт цаасны төлбөрт 10.0 тэрбум,
- Банкны бүтцийн өөрчлөлтийн хүрээнд гаргасан үнэт цаас төлбөрт 11.1 тэрбум,
- Жижиг, дунд үйлдвэр, ноос, ноолуурын салбарыг дэмжих зорилгоор гаргасан үнэт цаасны үндсэн төлбөрт 9.3 тэрбум,
- Засгийн газрын өрийн бичгийн үндсэн төлбөрт 29.9 тэрбум,

[5] *Шинээр гаргах болон дахин санхүүжүүлэх Засгийн газрын он дамжих үнэт цаас 1,400,000.0 сая төгрөг;*

- Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх үнэт цаасны үндсэн төлбөрт 1,319.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын өрийн нийт үлдэгдлийг сүүлийн 3 жилийн байдлаар харуулбал:

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он
ЗГ-ын гадаад зээлийн үлдэгдэл	2,935.5	3,613.2	3,979.1
ЗГ-ын гадаад үнэт цаасны үлдэгдэл	2,088.2	2,481.2	2,828.4
ЗГ-ын өрийн баталгааны үлдэгдэл	807.4	1,160.2	2,544.4
ЗГ-ын гадаад өр	**5,831.1**	**7,254.6**	**9,351.9**
ЗГ-ын дотоод үнэт цаасны үлдэгдэл	1,009.6	1,849.6	2,964.1
ТӨ ба ТӨ давамгайлсан хуулийн этгээдийн өр	1,525.5	1,629.3	1,438.3
ОНӨ ба ОНӨ давамгайлсан хуулийн этгээдийн өр	174.9	174.9	174.9
Татварын урьдчилгаа төлбөр /Оюутолгой/	385.5	372.5	138.7
ЗГ-ын дотоод өр	**3,095.5**	**4,026.3**	**4,716.0**
Өрийн нийт дүн	**8,926.6**	**11.280.9**	**14,067.9**

Монгол Улсын 2014 оны өрийн хэмжээ өмнөх оноос 2,787.0 тэрбум төгрөгөөр өссөн ба гадаад зээлийн үлдэгдэл 28.3, дотоод үнэт цаасны үлдэгдэл 21.3, гадаад үнэт цаасны үлдэгдэл 20.1, ЗГ-ын өрийн баталгаа 18.1, бусад өр 12.4 хувийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн МИАТ компаний худалдан авсан "Боинг 767-300ER" агаарын хөлгийн Засгийн газрын баталгаатай үндсэн зээл, хүүгийн төлбөрт нэг удаагийн дэмжлэг үзүүлэх тухай Засгийн газрын 2014 оны 155 дугаар тогтоолын дагуу нийт 4.2 сая ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө буюу 7.5 тэрбум төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас зарцуулсан ба нөөц сангаас гаргасан хөрөнгийг 2014 онд багтаан буцаан төлүүлэхийг холбогдох яам, агентлагт үүрэг болгосон боловч хэрэгжээгүй байна.

Зээлийн хүүгийн зардлыг хугацааны дагуу төлж байна

2014 онд 509.1 тэрбум төгрөгийн зээлийн хүү төлөхөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 500.3 тэрбум төгрөг буюу 98.3 хувийн биелэлттэй байна. Зээлийн хүүгийн зардлыг бүтцээр нь харуулбал:

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2013 оны гүйцэтгэл	2014 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Гадаадын зээлийн үйлчилгээний төлбөр	**32.2**	**172.7**	**171.5**	**-1.2**	**99.3**
Чингис бондын хүү	*0*	*130.7*	*130.7*	*0*	*100.0*
Гадаадын зээлийн хүү	*32.2*	*42.0*	*40.8*	*-1.2*	*97.1*
Дотоодын зээлийн хүү	**238.2**	**336.4**	**328.8**	**-7.6**	**97.7**
Улсын зээллэгээ, бондын хүү	*228.9*	*244.4*	*236.8*	*-7.6*	*96.9*
Засгийн газрын өрийн бичгийн мөнгөжүүлэлт	*0*	*30.0*	*30.0*	*0*	*100.0*
Банкны зээлийн хүүгийн төлбөр	*9.4*	*62.0*	*62.0*	*0*	*100.0*
Зээлийн үйлчилгээний нийт төлбөр	**270.4**	**509.1**	**500.3**	**-8.8**	**98.3**
Үүнээс: Улсын төсөв	*261.1*	*447.1*	*438.3*	*-8.8*	*98.0*
Хүний хөгжил сангийн төсөв	*8.5*	*62.0*	*62.0*	*0*	*100.0*
Орон нутгийн төсөв	*0.8*	*0*	*0*	*0*	*0*

Засгийн газрын шугамаар гадаад орон, олон улсын байгууллагаас авсан зээлийн хүүгийн төлбөрт 2014 онд 171.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд Засгийн газрын авч ашигласан зээл, хүүгийн зардалд 244.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 236.8 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Үүнд:

- *Төрийн албан хаагчид болон иргэдийг орон сууцжуулах "4000 айлын орон сууц" хөтөлбөрийн хүрээнд гаргасан хүүгийн зардалд 3.5 тэрбум төгрөг,*
- *Банкны бүтцийн өөрчлөлтийн хүрээнд өмнөх онуудад гаргасан бондын хүүгийн зардалд 0.03 тэрбум төгрөг,*
- *Ноос ноолуурын болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор гаргасан бондын хүүгийн зардалд 1.7 тэрбум төгрөг,*
- *Төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор тайлант онд гаргасан 1,467.0 тэрбум төгрөгийн бондын хүүгийн зардалд 166.0 тэрбум төгрөг,*
- *Хөгжлийн банкнаас олон улсын зах зээлд гаргасан 260.7 сая ам.долларын бондын хүүгийн зардалд 65.6 тэрбум төгрөг*

Мөн Мандалговь-Тавантолгой-Оюутолгойн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлын санхүүжилтийн үлдэгдэлд гаргасан 3Г-ын өрийн баталгаанд 30.0 тэрбум, ХХС-гийн бондын хүүгийн болон Оюутолгой ХХК-иас урьдчилгаа төлбөр хэлбэрээр авсан зээллэгийн хүүгийн төлбөрт 62.0 тэрбум төгрөгийг тус тус төлжээ.

Буцаан төвлөрүүлэхээр төлөвлөсөн зээлийн 52.4 хувь нь төлөгдөөгүй байна

2014 оны Төсвийн тухай хуулиар 10 ТЕЗ-ын төсвийн багцад дотоод эх үүсвэрээс 118.1 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 48.3 тэрбум төгрөг, нийт 166.4 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх зээлийг олгож, харин өмнөх онуудад олгосон зээлээс 166.9 тэрбум төгрөгийг буцаан төвлөрүүлэхээр баталсан байна. Хүснэгтээр харуулбал:

/тэрбум төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	*Төсөл хөтөлбөрийн нэр*	*2014 оны*		*Зөрүү*
		Төлөвлөгөө	*Гүйцэтгэл*	
Олгосон зээл, үүнээс		**166.4**	**159.6**	**(6.8)**
Барилга хот байгуулалтын сайд	Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл	25.1	43.4	18.3
Зам тээврийн сайд	Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төсөл	2.0	2.7	0.7
Эрчим хүчний сайд	Дарханы ДЦС-ын турбины шинэлэлт төсөл	4.8	7.2	2.4
	Эрчим хүчний үр ашиг төсөл	12.4	9.6	(2.8)
Хөдөлмөрийн сайд	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" сан	17.0	17.0	-
Аж үйлдвэрийн сайд	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан	36.0	30.6	(5.4)
Хүнс, хөдөө аж ахуйн сайд	Зах зээл, бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл	1.2	0.9	(0.3)
	Мал хамгаалах сан	1.5	1.5	-
Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд	Сургалтын төрийн сан	21.6	13.9	(7.7)
Сангийн сайд	Олгох зээл /5 төсөл, арга хэмжээ/	44.8	32.8	(12.0)
Буцаан төвлөрсөн зээл, үүнээс		**(166.9)**	**(79.5)**	**87.4**
Аж үйлдвэрийн сайд	ЖДҮДСан 3Г бонд, дамжуулан зээл	(50.0)	(50.0)	-
Хүнс, хөдөө аж ахуйн сайд	Тариалан эрхлэлтийг дэмжих сан	(24.0)	-	24.0
Шадар сайд	Улсын нөөцийн газар	(5.0)	(1.1)	3.9
Хууль зүйн сайд	Банк, хадгаламж зээлийн хоршооны ажлын алба	(22.2)	-	22.2
Сангийн сайд	Төлөгдөх зээл /4 арга хэмжээ/	(65.7)	(28.4)	37.3
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн дүн		**(0.5)**	**80.1**	**80.6**

2014 онд дамжуулан зээлдүүлэх зээл Эрчим хүчний болон ХХААС-ын багцад 13.6 тэрбум төгрөгөөр төлөвлөгдөж, 10.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 3.1 тэрбум төгрөгийн хэмнэлттэй байхад харин Барилга, хот байгуулалт, Зам тээвэр, Эрчим хүч, Сангийн сайдын төсөвт 34.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 58.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 24.2 тэрбум төгрөгөөр хэтэрчээ.

Улсын төсөвт буцаан төвлөрүүлэх зээлийн төлөвлөгөөг 87.4 тэрбум төгрөгөөр буюу 52.4 хувиар дутуу биелүүлсэн байна. Тухайлбал,

Сангийн сайд:

- *Улсын төсвөөс аж ахуйн нэгж болон төсөвт байгууллагад дамжуулан зээлдүүлсэн зээлээс 6.3 тэрбум төгрөг,*
- *Зоос банкны эрх хүлээн авагчаас төлөвлөснөөс авах авлагыг 21.0 тэрбум төгрөг,*
- *Анод банкны авлагатай этгээдүүдээс авлагыг бүрэн барагдуулахад тус банкны актив хөрөнгө хүрэлцэхгүйгээс 10.0 тэрбум төгрөг,*

Хүнс, хөдөө аж ахуйн сайд:

- *Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас Монгол Улсыг хөгжүүлэх санд төлөх улаан буудайн үлдэгдлийг тодорхойлж, өр авлагаа тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс 24.0 тэрбум төгрөг,*

Хууль зүйн сайд:

- *Дампуурсан хадгаламж зээлийн хоршооны хохирогчдын төлбөр барагдуулах ажлын явц удаашралтай байгаагаас 22.2 тэрбум төгрөг,*

1.4 Нэгдсэн төсвийн тэнцэл

2014 онд нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 1,484.1 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн нийт тэнцэл 636.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталсан боловч гүйцэтгэлээр урсгал тэнцэл 981.0 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 867.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ба 2013 оны гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал тэнцлийн ашиг 403.1 тэрбум төгрөгөөр буурч, нийт тэнцэлийн алдагдал 643.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Хүснэгтээр харуулбал,



	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
ДНБ оны үнээр	8,414.5	10,829.6	14,012.0	17,550.2	21,937.2
Төсвийн нийт орлого	3,122.5	4,227.2	4,881.2	5,940.1	6,276.6
Төсвийн нийт зарлага	3,080.7	4,997.0	6,017.8	6,164.7	7,144.6
Төсвийн нийт тэнцэл	41.8	-769.9	-1,136.6	-224.6	-867.9

Нэгдсэн төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор тайлант онд 2,425.8 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас арилжаалж, 369.0 тэрбум төгрөгийн зээлийг нэмж авсан байна.

Дээрх эх үүсвэрүүдээс Засгийн газрын үнэт цаасны эргэн төлөлтөд 1,374.9 тэрбум, Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөлтөд 116.4 тэрбум, ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанкаас авсан зээллэгийн эргэн төлөлтөд 110.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, үлдэх 1,193.5 тэрбум төгрөгийг 2014 оны нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлснээр харилцах болон хадгаламжийн дансдын үлдэгдэл 144.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ ТӨСӨВ

2.1 Улсын төсвийн орлого

Экспорт, импортын бууралтаас шалтгаалан төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна

2014 онд Улсын төсвийн орлого ба тусламжийн дүнг 4,770.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,244.3 тэрбум төгрөгийн орлого олж, төлөвлөгөө 88.9 хувийн биелэлттэй буюу 525.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь эрдэс бүтээгдэхүүний үнэ, тоо хэмжээ, экспорт, импортын бууралтаас шалтгаалсан байна. Хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	2012 гүйц	2013 гүйц	2014 төлөв	2014 гүйц
ДНБ-ий бодит өсөлт /хувь/	12.3	11.6	14.8	7.4
Экспорт /сая ам.доллар/	4,384.6	4,272.7	8,203.0	5,614.3
Импорт /сая ам.доллар/	6,738.4	6,354.7	7,383.0	5,253.7
Ам.долларын ханш /төг/	1,257.1	1,523.9	1,765.0	1,818.1

2014 оны Улсын төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

(тэрбум төгрөгөөр)

Төсвийн орлогын ангилал, зүйл	2014 он			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**4,770.1**	**4,244.3**	**-525.8**	**88.9**
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	**29.8**	**39.9**	**10.1**	**133.9**
1. ХХС – АМНАТ	16.7	14.3	-2.3	85.6
2. ХХС – ӨННАТ	13.1	25.6	12.5	195.4
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**4,740.3**	**4,204.4**	**-535.9**	**88.7**
А. УРСГАЛ ОРЛОГО	**4,557.9**	**4,022.7**	**-535.2**	**88.3**
I. ТАТВАРЫН ОРЛОГО	**3,885.9**	**3,119.6**	**-766.3**	**80.3**
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	782.0	621.2	-160.8	79.4
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,702.4	1,371.7	-330.7	80.6
Онцгой албан татвар	597.7	454.4	-143.3	76.0
Тусгай зориулалтын орлого	12.1	11.6	-0.5	95.9
Гаалийн албан татвар	426.2	355.3	-70.9	83.4
Бусад татвар	365.4	305.4	-60.0	83.6
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	**671.9**	**903.1**	**231.2**	**134.4**
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	**0**	**0**	**0**	**0**
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	**182.4**	**181.7**	**-0.7**	**99.6**

Тайлант онд төлөвлөсөн хэмжээнээс татварын орлого 766.3 тэрбум төгрөгөөр буурч, харин татварын бус орлого 231.2 тэрбум төгрөгөөр давж биелжээ.

Улсын төсөвт төвлөрсөн нийт татварын орлогын 16.6 хувийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК, 11.3 хувийг “Оюутолгой” ХХК, 6.7 хувийг “АПУ” ХХК, 2.7 хувийг “Монгол Улсын Хөгжлийн банк”, 2.5 хувийг “Монголтамхи со” ХХК, 2.4 хувийг “Эрдэнэс таван толгой” ХК, 57.8 хувийг бусад аж ахуйн нэгж, байгууллагууд тус тус бүрдүүлсэн байна.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 572.4 мянган тонн зэсийн баяжмал, 3,058.5 тонн молибдены баяжмал олборлож төсөвт 426.4 орчим тэрбум төгрөгийн татвар, ногдол ашгийн орлогыг төвлөрүүлсэн бол “Оюу толгой” ХХК 2014 онд 805.7 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэн борлуулж, төсөвт нийт 300.5 тэрбум төгрөгийн татвар төлжээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар. ААНОАТ-аар 2014 онд 782.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 621.2 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 20.6 хувиар буюу 160.8 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 38.9 тэрбум төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан байна.

ААНОАТ-ын бууралтад төгрөгийн ам.доллартай харьцах ханш өмнөх оноос суларснаас аж ахуйн нэгжүүдийн зардал, валютын ханшны зөрүүгийн алдагдал нэмэгдсэн, өмнөх онтой харьцуулахад арилжааны банкнаас аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл 16.1 хувиар буурч, аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадвар болон санхүүгийн байдал, ашигт ажиллагаа буурсан нь нөлөөлжээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг гол бүрдүүлэгч уул уурхайн салбарын, тэр дундаа зэс, нүүрс, алт, жонш, төмрийн хүдрийн олон улсын зах зээлийн үнэ манай улсын экспортод шууд нөлөөлж, үүнээс хамаарч борлуулалтын орлого буурч байна.

Сүүлийн 5 жилийн судалгаагаар аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгчдийн тоо жилд дунджаар 10713 татвар төлөгчөөр буюу 12.9 хувиар өссөн ба 2010 онд татвар төлөгчдөөс хүлээн авсан ААНОАТ-ын тайлангийн 58.0 хувь нь “Х” болон алдагдалтай тайлан ирүүлж байсан бол 2014 оны жилийн эцсийн байдлаар 61.8 хувь болж 3.8 пунктээр өссөн байна. Хүснэгтээр харуулбал:

Он	Тайлан ирүүлбэл зохих татвар төлөгчийн тоо	Тайлан ирүүлсэн татвар төлөгчийн тоо	Үүнээс: “Х” тайлан	Алдагдалтай тайлан	Ногдолтой тайлан	Тайлан ирүүлээгүй татвар төлөгчийн тоо	Ирц хувь
2010	62 232	55 535	22 831	9 390	23 314	6 697	89.2
2011	73 287	62 765	23 581	9 481	29 703	10 572	85.6
2012	82 479	69 453	26 184	10 828	32 441	13 026	84.2
2013	92 791	73 700	24 319	12 369	33 945	19 091	79.4
2014	105 085	79 330	29 931	19 115	30 284	25 755	75.5

Эх сурвалж:Сангийн яамны мэдээлэлд суурилав.

2014 онд татварын байгууллагад тайлан ирүүлсэн 79.3 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 49.4 мянган нь үйл ажиллагаа явуулаагүй болон алдагдалтай ажилласан нь ААНОАТ-ын төлөвлөгөө тасрахад багагүй нөлөө үзүүлжээ.

Мөн улсын төсөвт төвлөрүүлсэн ААНОАТ төлөлтийг шатлалаар нь авч үзвэл аж ахуйн нэгж, байгууллагын 45.9 хувь 100.0 мянган төгрөг хүртэлх, 36.4 хувь 100.0 мянгаас-1.0 сая төгрөг, 12.4 хувь 1.0-10.0 сая төгрөгийн татвар төлсөн ба зөвхөн 5.3 хувь нь 10.0-115.0 сая төгрөгийн татвар төлөгч байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвараар улсын төсөвт 2014 онд 1,371.7 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 330.7 тэрбум төгрөгөөр тасарчээ. НӨАТ-ын 37.6 хувийг дотоодын барааны, 62.4 хувийг импортын барааны татвар эзэлж байна.

Тайлант онд НӨАТ төлөгч 30.5 мянган аж ахуйн нэгж байгууллагын 90.5 хувь нь тайлан ирүүлснээс 27.8 хувь буюу 7.7 мянган татвар төлөгч үйл ажиллагаа явуулаагүй, тайлангаарх илүү, дутуу ногдлын зөрүүгээр нийт 363.8 тэрбум төгрөгийн татвар ногдуулж, 171.7 тэрбум төгрөгийн татварын авлагатай байна.

Улсын төсөвт төвлөрүүлсэн дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар төлөлтийг шатлалаар нь авч үзвэл дараах байдалтай байна.

Төлсөн татварын хэмжээ мян төг	*Аж ахуйн нэгжийн тоо*	*Дүнд эзлэх хувь*
0-50.0	1567	8.31
50.0-500.0	4265	22.62
500.0-5,000.0	6995	37.10
5,000.0-10,000.0	1800	9.55
10,000.0-15,000.0	941	4.99
15,000.0-70,000.0	2296	12.18
70,000.0-с дээш	991	5.26
Дүн	18855	100

Хүснэгтээс харахад тайлант онд аж ахуйн нэгж, байгууллагын 37.1 хувь нь 0.5-5.0 сая төгрөгийн, 5.26 хувь нь 70.0 сая төгрөгөөс дээш татвар төлжээ.

2014 онд импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлогоор 916.6 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 86.4 тэрбум төгрөгөөр тасарсан нь импортын хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс 2.1 тэрбум ам.долларoор буурсантай холбоотой байна.

Онцгой албан татварын орлогоор 597.7 тэрбум төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 454.4 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 24.0 хувиар буюу 143.3 тэрбум төгрөгөөр тасарсан нь импортын хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Онцгой албан татварын 51.5 хувийг дотоодын барааны, 48.5 хувийг импортын барааны татвар эзэлж байна. Тайлант онд улсын төсөвт төвлөрсөн дотоодын барааны онцгой албан татварын хэмжээг харуулбал:

(тэрбум төгрөг)

Улсын төсөвт төвлөрүүлсэн ОАТ	*гүйцэтгэл*				*2014*	
	2010	*2011*	*2012*	*2013*	*төл*	*гүйц*
Дотоодын архи, дарс	68	67.9	92.6	148.2	136.6	160.3
Дотоодын пиво	12.2	14.5	17.6	21.8	24.0	27.9
Дотоодын тамхи	11.4	9.9	15.7	39.6	41.5	45.7
Нийт орлого	91.6	92.3	125.9	209.6	202.1	233.9

2014 онд дотоодын барааны онцгой албан татварын орлогоор 233.9 тэрбум төгрөг төсөвт төвлөрч, төлөвлөгөө 31.8 тэрбум төгрөгөөр давж биелжээ.

(тэрбум төгрөг)

Улсын төсөвт төвлөрүүлсэн импортын ОАТ	*2013*	*2014*	
	гүйц	*төл*	*гүйц*
Автобензин, дизелийн түлш	45.4	85.6	22.1
Суудлын автомашин	104.4	164.3	90.3
Импортын архи, тамхи	79.9	133.9	100.1
Импортын пиво	10.1	11.7	7.9
Нийт орлого	239.8	395.5	220.4

Импортын барааны онцгой албан татварын нийт дүнгээр 395.5 тэрбум төгрөгийн орлого оруулахаас гүйцэтгэлээр 220.4 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөө 44.3 хувиар буюу 175.1 тэрбум төгрөгөөр тасархад Засгийн газрын 2014 оны 24 дүгээр тогтоолоор автобензин, дизелийн түлшинд ногдох онцгой албан татварын хувь хэмжээг бууруулсан нь тодорхой хэмжээгээр нөлөөлжээ.

Гаалийн албан татвар 2014 онд гаалийн албан татвараар 426.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 355.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөө 16.7 хувиар буюу 70.9 тэрбум төгрөгөөр тасарсан нь импортын хэмжээ буурснаас шалтгаалсан байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр Татварын байгууллага тайлант онд нийт 793.8 тэрбум төгрөгийн АМНАТ-ийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласнаас гүйцэтгэлээр 617.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөө 176.6 тэрбум төгрөгөөр буюу 22.2 хувиар дутуу биелсэн байна.

АМНАТ-ийн орлогын гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй нь нүүрс, төмрийн хүдрийн дэлхийн зах зээлийн үнэ болон экспортын тоо хэмжээ буурснаас шалтгаалжээ.

- 31.4 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 19.5 сая тонн нүүрсний үнэ болон экспортын тоо хэмжээний бууралтаас шалтгаалж 120.5 тэрбум төгрөгийн татвар дутуу,
- 7.8 сая тонн төмрийн хүдэр олборлохоос 6.3 сая тонныг олборлож, төлөвлөснөөс 75.5 тэрбум төгрөгийн татвар дутуу төвлөрсөн байна.

Тусгай зориулалтын орлого Автобензин, дизелийн түлшний болон авто тээврийн хэрэгслэлийн албан татварын орлогоор нийт 39.9 тэрбум төгрөг олж, төлөвлөгөө 99.5 хувийн биелэлтэй байна.

Бусад татвар (төлбөр, хураамж) Уг татвараар нийт 365.4 тэрбум төгрөгийн орлого орохоос гүйцэтгэлээр 305.4 тэрбум төгрөгийн орлого олж, төлөвлөснөөс 16.4 хувь буюу 60.0 тэрбум төгрөгийн орлого дутуу төвлөрсөн байна.

Татварын бус орлого төлөвлөсөн хэмжээнээс давж биелжээ

2014 онд татварын бус орлогоор 671.9 тэрбум төгрөг төвлөрөхөөс гүйцэтгэлээр 903.1 тэрбум төгрөгийн орлого олж, төлөвлөгөөг 34.4 хувиар буюу 231.2 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Татварын бус орлогын бүтцийг графикаар харуулбал:

Татварын бус орлого нийт дүнгээрээ биелсэн ч зарим орлого тасарсан байна. Тухайлбал:

- *Түрээсийн орлогоор* “МТЗ” ТӨХК-иас 0.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр баталсан ч гүйцэтгэл гараагүй нь 7.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан, тус компаний хөдлөх бүрэлдэхүүнийг түрээслэгч “УБТЗ” ХНН ашиглалтын төлбөрөө төлөөгүйгээс,
- *Өмч хувьчлалын орлогоор* 25.0 тэрбум төгрөг оруулахаар төлөвлөсөн боловч “2014-2016 онд төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл”-ийг УИХ-аас батлаагүйгээс орлого төвлөрөх боломжгүй болж, харин Засгийн газрын шийдвэрээр хувьчлалаас гадуур төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдаанаас 11.3 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 45 хувь тасарсан,
- *Ногдол ашгийн орлогоор* 9.7 тэрбум төгрөгийн орлого оруулахаас гүйцэтгэлээр 7.6 тэрбум төгрөг орж, төлөвлөснөөс 2.1 тэрбум төгрөг дутуу төвлөрсөн ба Төрийн банк, Хөгжлийн банк 6.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлээгүй,
- *Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан* тайлант онд 0.7 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулаагүй,
- *Дипломат төлөөлөгчийн газрын* улсын тэмдэгтийн хураамжаар тайлант онд Засгийн газрын 2014 оны 186 дугаар тогтоол хэрэгжсэнтэй холбоотойгоор 0.7 тэрбум төгрөг дутуу төвлөрсөн,
- *Мэргэжлийн хяналтын ерөнхий газар* Засгийн газрын 2014 оны 132 дугаар тогтоолын дагуу санхүүгийн хяналтын чиг үүрэг шилжсэнтэй холбогдож торгуулийн орлого 49.0 хувиар тасарсан,
- *Ашигт малтмалын газрын* бусад орлогын төлөвлөгөө 11.0 хувиар тасарсан нь кадастрын болон геологийн үйлчилгээ, архивын орлого тасарснаас,
- *Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төв* бусад орлого 49.3 хувиар тасарсан нь 2014 онд шинээр барихаар төлөвлөж байсан авто зам, гүүрийн ажлын төсөвт зардал батлагдаагүй, зарим хөрөнгө оруулалтын санхүүжилт хугацаанд хийгдээгүйтэй холбоотой байна.

2.2 Улсын төсвийн зарлага

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн зарлагыг 5,594.8 тэрбум төгрөгөөр баталсан боловч тодотголоор 5,631.4 тэрбум төгрөгөөр баталж анхны дүнгээс 0.7 хувь буюу 36.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Улсын төсвийн нийт зарлага 5,229.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, үүнээс урсгал зардалд 3,910.2 тэрбум, хөрөнгийн зардалд 1,238.8 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээлд 80.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Нийт зарлагын 23.0 хувийг БСШУС, 18.0 хувийг СС, 11.2 хувийг ЭМСС, 7.2 хувийг ХАХНХС, 6.7 хувийг ЗТЯ, 3.5 хувийг ЭХС, 30.4 хувийг бусад ТЕЗ-дын зарлага эзэлж байна.

Засгийн газраас гаргасан 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй, хяналт тавьж хариуцлага тооцож ажиллаагүй байна.

Улсын төсвийн зарлага нэгдсэн дүнгээр хэтрээгүй боловч зардлын зүйлээр авч үзэхэд байрны түрээсийн зардалд 0.5 тэрбум, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэгт 4.9 тэрбум, урьд оны өрөнд 14.7 тэрбум төгрөгийг төлөвлөсөн хэмжээнээс илүү зарцуулжээ.

ХХААС-ын багцаас "урьд оны өрийг төлсөн" зардал нь ТЭДС-гийн 2014 оны үйл ажиллагааны орлогоос 2013 онд тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдээс худалдан авсан улаан буудайд 4.3 тэрбум, хор бордоо нийлүүлэгч аж ахуйн нэгжид 2.8 тэрбум, КР-1 төсөлд 4.0 тэрбум, бага оврын тракторын үнэнд 2.0 тэрбум, шатахууны 2.8 тэрбум төгрөгийн өглөгийг барагдуулсан хоорондын тооцооны гүйлгээг төсвийн гүйцэтгэлээр тайлагнасантай холбоотой байна.

Харин суралцагчдад олгох сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардал 4.9 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь,

- *гадаад улс оронд баклаварын сургалтад суралцагсдын тоо нэмэгдсэн болон ханшийн зөрүүгээс шалтгаалан 1.7 тэрбум;*
- *Засгийн газрын 71 дүгээр тогтоолын дагуу эцэг, эх нь хөдөлмөрийн чадвараа алдсан өрхөөс суралцагсад төлөвлөснөөс 260-аар өссөн, сургуулиудын сургалтын төлбөр нэмэгдснээс шалтгаалан 3.2 тэрбум.*

Улсын төсвөөс бусад шатны төсөв болон хувийн хэвшлийн байгууллагад дараах зориулалтаар татаас, шилжүүлэг олгожээ.Үүнд:

- *Сум хөгжүүлэх санд 12.0 тэрбум;*
- *Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сан 2.0 тэрбум;*
- *Улаан буудайн урамшуулалд 17.8 тэрбум;*
- *Махны урамшуулалд 9.5 тэрбум;*
- *Ноосны урамшуулалд 18.3 тэрбум;*
- *Арьс ширний урамшуулалд 2.3 тэрбум.*

ТЕЗ-дын төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд багцын дүнгээр хэтрээгүй ч урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн, төлөвлөөгүй төсөл хөтөлбөрийг санхүүжүүлсэн, ханшийн зөрүүгээс шалтгаалан зарим зардал хэтэрсэн байна. *Тухайлбал, ШЕЗ 2.0 тэрбум, ГХС 6.1 тэрбум, ЗТС 0.8 тэрбум, ЭМСС 1.8 тэрбум төгрөг гэх мэт.*

Төрийн байгууллага, ажилтны буруутай үйл ажиллагааны нөхөн төлбөрийн зардалд шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн ХЗС-ын тушаалаар гэрээний үүргээ биелүүлээгүй нөхөн төлбөрт 4.1 тэрбум төгрөг олгожээ.

Аудитын явцад судалгаа хийж үзэхэд төрийн албан хаагчдад ажилгүй байсан хугацааны цалинг олгохоор гаргасан шүүхийн шийдвэрийн дагуу улсын төсвөөс 52.5 сая, орон нутгийн төсвөөс 566.8 сая төгрөг олгосон ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар 339.4 сая төгрөг барагдуулсан байна.

Хөтөлбөрт суурилсан төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах нэгдсэн аргачлал, арга зүй байхгүй байна

2014 оны Төсвийн тухай хуулиар ТЕЗ-дын үндсэн чиг үүрэгт хамаарах 103 хөтөлбөрийн 317 арга хэмжээг хүрэх үр дүн, зорилтот түвшинөөр нь баталсан байна.

Төсвийг хөтөлбөрт суурилан төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах нэгдсэн арга зүй, журам байхгүй байна. Иймээс ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн зорилтот түвшин, гүйцэтгэл нь ихээхэн зөрүүтэй тайлагнагдаж байна:

- ***СЗХ*** *санхүүгийн салбарын зохицуулалтын хүрээнд олгох зөвшөөрлийн тоог 3362 гэж төлөвлөн 993-ыг олгосон;*
- ***ШӨХТГ****-аас өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийн чиглэлээр хийх сургалт, сурталчилгааны тоо 85 байхаас 4 удаа;*
- ***ХААГ-****аас мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах худалдан авалтыг 400-аар төлөвлөж 275 явуулсан;*
- ***БОНХАЖЯ*** *эвдэрсэн газрыг нөхөн сэргээх талбайн хэмжээг 1500.0 га байхаар төлөвлөж 806.9 га-д;*
- *ХЗЯ-наас эрх зүйн бодлогын төлөвлөлт, зохицуулалтын хүрээнд 860 баримт бичиг боловсруулахаас 716, сургалт сурталчилгааг 300 зохиохоос 60 сургалт, 112 сурталчилгаа;*
- ***АҮЯ*** *жижиг зээлийн хүрээнд бий болсон ажлын байрны тоог 20.0 мянгад хүргэхээс 6.4 мянга хүрсэн байна.*

Зарим ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт төсөвт хөрөнгө төлөвлөгдөөгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.Тухайлбал,

- ***ЗТС-ын*** *хэрэгжүүлэх Богдхан уулын урдуур шинэ төмөр зам барих, 2000 км шинэ төмөр зам барих, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн зураг, төсөл боловсруулах;*
- ***БХБС-ын*** *хэрэгжүүлэх хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, өндрийн сүлжээний давтан болон нивелирдлэг хийх шугамын хэмжилтийн тоо,*
- ***БОНХАЖС-ын*** *хэрэгжүүлэх ус, цаг уурын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг бэхжүүлэх, лаборатори, нэгжийн тоо,*
- ***ШС-ын*** *оюуны өмчийн чиглэлээр хэрэгжүүлэх аж үйлдвэрийн өмч, зохиогчийн эрх, оюуны өмчийн гэрээ хэлэлцээрийн баталгаажилт, оюуны өмчийн мэдээлэл, сургалтын тоон үзүүлэлт*

ТЕЗ-дын төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээний 13.8 хувь буюу 44 нь дутуу, 10.4 хувь буюу 33 нь хэрэгжээгүй байна.

2.3 Улсын төсвийн тэнцэл

2014 онд Улсын төсвийн урсгал тэнцэл 326.0 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 891.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр урсгал тэнцэл 112.5 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 1,024.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Тайлант оны урсгал тэнцлийн алдагдлын хэмжээг өмнөх онтой харьцуулахад 352.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2014 оны Улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 2,156.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг ЗГ-ын үнэт цаас арилжаалснаар бүрдүүлсэн ба 353.2 тэрбум төгрөгийн зээл гадаадаас авч ашигласан байна.

Дээрх эх үүсвэрүүдээс ЗГ-ын үнэт цаасны эргэн төлөлтөд 1,320.0 тэрбум, ЗГ-ын гадаад зээлийн эргэн төлөлтөд 116.4 тэрбум, ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд Монгол банкаас авсан зээллэгийн эргэн төлөлтөд 110.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулснаар тайлант хугацаанд харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 235.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН 2014 ОНЫ ТӨСӨВ

3.1 Орон нутгийн төсвийн орлого

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө биелжээ

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулиар Улсын төсвөөс орон нутагт 159.2 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгох, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрт 3 аймгаас 71.3 тэрбум төгрөг төвлөрүүлэх, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 284.4 тэрбум төгрөгөөр баталсан ба УИХ-аас Төсвийн тухай хуульд 2 удаа өөрчлөлт хийсэнтэй уялдаж орон нутгийн төсөвт дараах өөрчлөлтүүдийг оруулж тодотгож баталжээ.

Хуульд орсон энэхүү өөрчлөлтөөр Булган аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 2.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, харин орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх орлогыг Өмнөговь аймгаас 19.1 тэрбум төгрөгөөр, нийслэлээс 2.4 тэрбум төгрөгөөр тус тус бууруулжээ.

(*тэрбум төгрөг*)

Эдийн засгийн ангилал	*Баталсан*	*Тодотгол[1] /2014.05.23/*	*Тодотгол[2] /2014.12.18/*
Улсын төсвөөс орон нутагт олгох санхүүгийн дэмжлэг	159.2	158.6	161.0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд 3 аймгаас төвлөрөх хөрөнгө	71.3	71.7	52.7
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	284.4	284.8	265.8

2014 оны төсвийн тодотголоор орон нутгийн төсвийн нийт орлогыг анх батлагдсанаас 7.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 2.1 тэрбум төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 2014 оны батлагдсан төсвийг өмнөх онтой харьцуулбал 11.6 хувиар өссөн байна.

(*тэрбум төгрөг*)

Орлогын нэр	*Батлагдсан төсөв*		*Өөрчлөлт*
	2013 он	*2014 он*	
Урсгал орлогын дүн	733.3	809.2	75.9
Татварын орлого	656.0	696.3	40.3
Татварын бус орлого	77.3	112.9	35.6
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	2.1	2.2	0.1
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	1,154.6	1,327.0	172.4
Нийт орлого ба тусламжийн дүн	**1,890.0**	**2,138.4**	**248.4**

Орон нутгийн ИТХ-аас орон нутгийн төсөвт олон удаа өөрчлөлт оруулах, сумын ИТХ хурлаар төсвийн тодотгол хийсэн шийдвэрээ аймагт хүргүүлэхгүй байна. Тухайлбал,

- *Дундговь аймгийн ИТХ орон нутгийн төсвийг 2 удаа тодотгож, 4.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсний 1.5 тэрбум төгрөгөөр тодотгосон,*
- *Булган аймгийн ИТХ тодотгол хийгээгүй байхад сумын ИХТ-ууд 2-3 удаа тодотгол хийсэн,*
- *Говь-Алтай аймгийн ИТХ-ын тогтоолгүйгээр Алтай, Тайшир,Төгрөг, Цээл сумдын ИТХ 900.0-3520.0 мянган төгрөгөөр нэмж тодотгосон,*
- *Завхан аймгийн ИТХ давсан орлогыг 263.1 сая төгрөгөөр, сумдын ИХТ 436.3 сая төгрөгөөр нэмж тодотгон зарцуулсан,*
- *Архангай аймгийн ИТХ тавилга, эд хогшил худалдан авах зардлыг 84.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан,*
- *Баянхонгор, Ховд аймгийн зарим сумдын ИТХ баталсан тодотголоо тайланд буруу илэрхийлсэн байна.*

Орон нутгийн төсвийн орлогоор 2014 онд 2,092.2 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 46.2 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ.

Орон нутгийн төсвийн орлогын 59.5 хувийг тусламжийн, 34.2 хувийг татварын, 6.1 хувийг татварын бус, 0.2 хувийг хөрөнгийн орлого бүрдүүлж байгаа бөгөөд төсвийн гүйцэтгэлийг бүрэлдэхүүнээр харуулбал;

Орон нутгийн татварын орлого 2.8 хувиар буюу 19.5 тэрбум, татварын бус орлого 26.3 хувиар буюу 15.4 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн орлого 4.5 хувиар буюу 0.1 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн ба харин тусламжийн орлого 6.1 хувь буюу 81.2 тэрбум төгрөгөөр тасарчээ.

/тэрбум төгрөг/

Орлогын нэр, төрөл	*2014 он*		
	төлөв	*гүйц*	*хувь*
1. Татварын орлого	**696.3**	**715.8**	**102.8**
1.1. Орлогын албан татвар	462.4	479.8	103.8
1.2. Өмчийн албан татвар	50.2	50.1	99.8
1.3. Тусгай зориулалтын орлого	28.0	28.3	101.1
1.4. Бусад татвар	155.7	157.6	101.2
2. Татварын бус орлого	**112.9**	**128.3**	**126.3**
3. Хөрөнгийн орлого	**2.2**	**2.3**	**104.5**
4. Тусламжийн орлого	**1,327.0**	**1,245.8**	**93.9**
Нийт орлого, тусламжийн дүн	**2,138.4**	**2,092.2**	**97.8**

Тайлант онд орон нутгийн урсгал орлогын 84.8 хувийг татварын, 15.2 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Орон нутгийн татварын орлого төлөвлөгөөнөөс 19.5 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь урлаг, спортын тэмцээн болон наадмын бай шагналын орлогод ногдуулсан татварын орлого 83.1 хувиар, үйл ажиллагааны орлого 29.7 хувиар, цалин хөлс, шагнал урамшууллын орлого 2.0 хувиар тус тус илүү төвлөрсөнтэй холбоотой байна.

Татварын бус орлогоор 112.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 128.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөөг 15.4 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн нь төсөвт байгууллагын өөрийн орлого 11.4 тэрбум, хүү, торгуулийн орлого 2.3 тэрбум, бусад орлого 1.5 тэрбум, түрээсийн орлого 0.2 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөнтэй холбоотой байна.

Аймаг, нийслэлийн төсвийн 2014 урсгал орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

/ тэрбум төгрөг/

Аймаг, нийслэлийн нэр	**Төсвийн орлого**			**Аймаг, нийслэлийн нэр**	**Төсвийн орлого**		
	Төлөв-лөгөө	**Гүйцэт-гэл**	**Хувь**		**Төлөв-лөгөө**	**Гүйцэт-гэл**	**Хувь**
Архангай	5.6	6.5	116.1	Сүхбаатар	12.2	13.0	106.6
Баян-Өлгий	6.0	6.2	103.3	Сэлэнгэ	15.9	17.2	108.2
Баянхонгор	8.5	8.6	101.2	Төв	11.2	16.3	145.0
Булган	17.3	19.0	109.8	Увс	6.3	7.3	115.9
Говь-Алтай	7.6	8.4	110.5	Ховд	9.1	8.6	94.5
Дорноговь	15.6	16.1	103.2	Хөвсгөл	8.7	9.4	108.0
Дорнод	11.1	12.9	116.2	Хэнтий	8.4	8.5	101.2
Дундговь	4.1	4.5	109.8	Дархан-Уул	17.0	17.7	104.1
Завхан	6.1	6.9	113.1	Улаанбаатар	512.1	529.5	103.4
Өвөрхангай	8.7	9.4	108.0	Орхон	39.8	41.5	104.3
Өмнөговь	76.1	74.5	97.9	Говь-Сүмбэр	4.1	4.6	112.2
Бүгд дүн					**811.5**	**846.3**	**104.3**

Татварын орлогын төлөвлөгөөг Баянхонгор аймаг 489.4 сая, Хэнтий аймаг 226.2 сая, Өмнөговь аймаг 2,066.2 сая, Ховд аймаг 123.2 сая төгрөгөөр дутуу биелүүлжээ. Шалтгаан нь:

- ***Өмнөговь аймаг:*** *Усны нөөц ашигласны төлбөр тооцох итгэлцүүрийг ЗГ-ын 326, 327 дугаар тогтоолоор 45.5 хувиар бууруулж баталснаас, мөн "Оюутолгой ХХК нь 2013 оны ус ашигласны төлбөрийн төлөлтөөс 4.8 тэрбум төгрөгийг 2014 онд суутган тооцсоноос,*
- ***Хэнтий аймаг:*** *Дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр төлөвлөсөн тариалангийн газрын дуудлага худалдаа хийгдээгүйгээс төлбөрийн орлого биелэх боломжгүй болсон, Бор-Өндөр УҮГ үйлдвэрийн зориулалтаар ашигласан усны төлбөрөө хугацаандаа төлөөгүйгээс,*
- ***Баянхонгор аймаг:*** *Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа зарим аж ахуйн нэгж, байгууллага ус, рашаан ашигласны төлбөрийг бүрэн төлөөгүй, цалин, хөлс, шагнал урамшууллаас тооцдог татварын төлөвлөгөөг хэт өндөр баталснаас,*

- ***Хэнтий, Баянхонгор аймгууд:*** *Тээврийн хэрэгсэл эзэмшигчдийн улсын дугаарын бүртгэл Улаанбаатар болон бусад аймагт бүртгэлтэй байдгаас АТБӨЯХ-ийн албан татварын төлөвлөгөө тасарсан,*

Улаанбаатар хот, Өмнөговь, Орхон аймаг тайлант онд зарлагаас давсан 52.8 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлжээ.

2014 онд улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээр 17 аймагт 158.1 тэрбум төгрөг олгож, өмнөх оноос 3.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.2 Орон нутгийн төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн нийт зарлага 2,129.6 тэрбум буюу 89.7 хувийн гүйцэтгэлтэй гарч 245.5 тэрбум төгрөгийг хэмнэжээ.

Зарлагын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 359.7 тэрбум төгрөгөөр буюу 20.3 хувиар нэмэгджээ. Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэлийг харуулбал:

/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	*Төлөв*	*Гүйц*	*Зөрүү*	*Хувь*
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	**2,375.1**	**2,129.6**	**245.5**	**89.7**
Урсгал зардлын дүн	1,670.2	1,606.6	63.6	96.2
Бараа үйлчилгээний зардал	1,297.0	1,246.9	50.0	96.1
Татаас ба урсгал шилжүүлэг	373.2	359.8	13.4	96.4
Хөрөнгийн зардал	704.9	523.0	181.9	74.2

Орон нутгийн нэгдсэн төсвийн нийт зарлагын дүнд урсгал зардал 75.4 хувийг, хөрөнгийн зардал 24.6 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс урсгал зарлага 244.4 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 115.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн зарцуулалттай холбоотой байна.

Аймаг, нийслэлийн төсвийн 2014 оны зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

(тэрбум төгрөг)

Аймаг, нийслэлийн нэр	*Төсвийн зарлага*			*Аймаг, нийслэлийн нэр*	*Төсвийн зарлага*		
	Төл	*Гүйц*	*Зөрүү*		*Төл*	*Гүйц*	*Зөрүү*
Архангай	66.7	63.1	3.6	Сүхбаатар	56.0	53.7	2.3
Баян-Өлгий	70.4	66.6	3.8	Сэлэнгэ	71.5	67.6	3.9
Баянхонгор	68.2	64.7	3.5	Төв	68.8	66.5	2.3
Булган	57.1	50.6	6.5	Увс	65.2	63.0	2.2
Говь-Алтай	63.8	57.5	6.3	Ховд	66.0	62.1	3.9
Дорноговь	50.6	47.3	3.3	Хөвсгөл	92.8	88.2	4.6
Дорнод	58.8	56.0	2.8	Хэнтий	61.0	58.3	2.7
Дундговь	47.2	39.6	7.6	Дархан-Уул	57.8	53.2	4.6
Завхан	60.9	58.1	2.8	Улаанбаатар	931.4	770.1	161.3
Өвөрхангай	74.8	72.2	2.6	Орхон	79.0	74.0	5.0
Өмнөговь	134.6	127.2	7.4	Говь-Сүмбэр	19.6	17.4	2.2
Бүгд дүн					**2,322.4**	**2,076.9**	**245.5**

Тайлант онд орон нутгийн төсвийн урсгал зардал нь өмнөх оноос өсч 1,606.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа ба үүнээс 785.2 тэрбум төгрөг буюу 50.5 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл, 461.6 тэрбум төгрөг буюу 29.8 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 359.7 тэрбум буюу 19.7 хувийг татаас, урсгал шилжүүлэг, нийгмийн хамгааллын зардал тус тус эзэлж байна.

Хөрөнгийн зардал өмнөх оноос 115.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 522.9 тэрбум төгрөгт хүрч, нийт зарлагын 25.2 хувийг эзэлж байгаа нь орон нутгийн дотоод эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалтын санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн ТЕЗ, түүний харьяа байгууллагууд төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй төлөвлөх зарцуулах зарчмыг хэрэгжүүлэхгүй байна.Тухайлбал,

- *Улаанбаатар, Сэлэнгэ аймгийн ИТХ, ЗДТГ-ын гадаад томилолтын зардал өмнөх оноос өссөн,*
- *Улаанбаатар, Орхон аймгийн ИТХ, ЗДТГ-ын тээвэр шатахууны зардал өссөн,*
- *Улаанбаатар, Архангай, Дорнод, Баян-өлгий, Говьсүмбэр,Орхон, Хэнтий аймгийн ИТХ, ЗДТГ өндөр үнэтэй авто машин худалдан авсан,*
- *Төв, Говьсүмбэр аймгийн ЗДТГ нэмэлт санхүүжилтийг баяр наадам, ой тэмдэглэх, аймаг сурталчлах, туршлага судлах, тамгын газрын урсгал зардал, хурал зөвөлгөөн зэрэгт зарцуулсан,*

2014 оны Төсвийн тухай хуульд тусгасан цалингийн зардлыг тооцоход үндэслэл болгосон хяналтын тооноос аймгуудийн ИТХ 120 орон тоогоор нэмж батлан, гүйцэтгэлээр 1736 орон тоо ажилласан дүн гарч байна.

3.3 Орон нутгийн төсвийн тэнцэл

2014 онд орон нутгийн төсвийн урсгал тэнцэл 860.9 тэрбум төгрөгийн, нийт тэнцэл 236.6 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр урсгал тэнцэл 762.6 тэрбум төгрөгийн, нийт тэнцэл 37.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Орон нутгийн 2014 оны төсвийн нийт тэнцлийн алдагдлыг Засгийн газрын гадаад зээлээр 7.3 тэрбум төгрөгөөр, харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 229.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 15.9 тэрбум төгрөгийн гадаад зээл авч ашигласан ба тайлант оны эцэст орон нутгийн харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 21.6 тэрбум төгрөг байна.

БҮЛЭГ 4. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2014 ОНЫ ТӨСӨВ

4.1 Хүний хөгжил сангийн төсвийн орлого

Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулиар 549.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 427.0 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөөний биелэлт 77.7 хувьтай гарчээ. Хүснэгтээр харуулбал,

(тэрбум төгрөг)

Ангилал		*Төлөвлөгөө*	*Гүйцэтгэл*	*Зөрүү*
1. Нийт орлогын дүн		**549.8**	**427.0**	**-122.8**
1.1.	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	534.8	404.0	-130.8
1.2.	Хувьцааны ногдол ашиг	15.0	15.0	-
1.3	Хувьцаа борлуулсаны орлого		7.9	7.9

Орлогын гүйцэтгэл тасарсан гол шалтгаан нь:

- Олон улсын зах зээл дээрх гол нэрийн ашигт малтмалын үнэ буурсан,
- Нүүрсний борлуулалт буурсан, /нүүрсний үнэ тонн тутамд 40 хувиар буурсан/
- Төмрийн хүдрийн экспорт 8.0 сая тонн хийгдэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 5.0 сая тонн болсон нь нөлөөлсөн байна.

ХХС-гийн АМНАТ-ийн орлогын 296.3 тэрбум төгрөгийг мөнгөөр, үлдэх 101.1 тэрбум төгрөгийг Эрдэнэс тавантолгой болон Оюутолгой ХХК-уудтай байгуулсан урьдчилгаа төлбөрийн гэрээний дагуу тус компаниудад төлөх төлбөрийн үлдэгдлээс тэдгээрийн төсөвт төлөх татварт, Оюутолгой ХХК-д төлөх хүүгийн төлбөрт суутган тооцсон байна.

“Эрдэнэт Үйлдвэр” ХХК ногдол ашгийн төлөвлөсөн 15.0 тэрбум төгрөгийн орлогыг бүрэн төвлөрүүлжээ.

Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ий нийт хувьцааны 10 хүртэлх хувийг үндэсний аж ахуйн нэгж, байгууллагад санал болгон худалдсан хувьцааны төлбөр 7.9 тэрбум төгрөгийг ХХС-д төвлөрүүлсэн байна.

4.2 Хүний хөгжил сангийн төсвийн зарлага

ХХС-гаас 318.5 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсанаас 312.5 тэрбум төгрөг зарцуулж, 98.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Зардлын задаргааг харуулбал,

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт		***Төлөвлөгөө***	***Гүйцэтгэл***	***Зөрүү***
2.	**Нийт зарлагын дүн**	**318.5**	**312.5**	**- 6.0**
2.1	Төр хариуцан төлөх ЭМД-ын шимтгэл	12.0	12.0	-
2.2	Хүүхдийн мөнгө	239.0	238.5	0.5
2.3	ЗГ-ын бонд болон урьдчилгаа төлбөрийн хүүгийн зардал	62.0	62.0	-
2.4	Хөрөнгө оруулалт	5.5	-	-5.5

Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан 16 хүртэлх насны хүүхэд, өндөр насны тэтгэвэр авагч, хүүхдээ асарч буй эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хугацаат цэргийн албан хаагч, халамжийн тэтгэвэр авагч, их, дээд сургуулийн өдрийн ангийн суралцагчид нийт 1.5 сая иргэдийн төрөөс хариуцах ЭМДШ-ийн төлбөрт 12.0 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Тайлант онд 0-18 насны 1,013.9 мянган хүүхдэд сар бүр олгох 20 мянган төгрөгт Хүний хөгжил сангаас нийт 238.5 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Засгийн газрын гаргасан бондын хүүгийн зардалд 62.0 тэрбум төгрөг төлж, 2014 оны эцсийн байдлаар ХХС 479.5 тэрбум төгрөгийн Засгийн газрын бондын үлдэгдэлтэй байна.

4.3 Хүний хөгжил сангийн төсвийн тэнцэл

Хүний хөгжлийн сангийн 2014 оны нийт тэнцэл 231.3 тэрбум төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн, гүйцэтгэлээр 114.5 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Тус санд ЗГ-ын гаргасан үнэт цааснаас 269.8 тэрбум төгрөг төвлөрсөн ба сангийн нийт эх үүсвэрээс дараах төлбөр, суутгалуудыг хийжээ. Үүнд:

- Өмнөх онд гаргасан ЗГ-ын үнэт цаасны үндсэн төлбөрт 55.0 тэрбум төгрөг,
- Оюутолгой ХХК-ий урьдчилгаа төлбөр хэлбэрээр төвлөрүүлсэн 100 сая ам.доллар үнэт цаасны үндсэн төлбөрт 185.1 тэрбум төгрөг,
- “Эрдэнэс МГЛ” ХХК-ий төвлөрүүлсэн урьдчилгаа төлбөрийн үлдэгдлээс өр, авлагыг татварт суутгах 10.0 тэрбум төгрөг,
- “Оюутолгой” ХХК, “Эрдэнэс МГЛ” ХХК-ий татварын суутган тооцсон 173.4 тэрбум төгрөгийг татварын орлогод, үлдэх 101.1 тэрбум төгрөгийг ХХС-гийн орлогод тооцсон байна.

Тайлант оны эцэст Хүний хөгжил сангийн харилцах дансны үлдэгдэл 33.1 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

БҮЛЭГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2014 ОНЫ ТӨСӨВ

5.1 Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого

Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуулиар нийт 1,569.8 тэрбум төгрөгийн орлого оруулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 3250.5 мянган даатгуулагчаас 1,141.6 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулж, улсын төсвөөс 253.3 тэрбум төгрөгийн дэмжлэг авч, сангийн орлого нийт 1,394.9 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 11.1 хувиар буюу 174.9 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна. Орлогын төрлөөр харуулбал:

/тэрбум төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгал	785.2	705.3	-79.9	89.8
2	Тэтгэмжийн даатгал	87.2	78.4	-8.8	89.9
3	ҮОМШӨ-ний даатгал	90.3	99.8	9.5	110.5
4	Ажилгүйдлийн даатгал	26.4	26.3	-0.1	99.6
5	Эрүүл мэндийн даатгал	260.6	231.8	-28.8	88.9
6	Төр хариуцах тэтгэвэр	320.1	253.3	-66.8	79.1
	Дүн	**1,569.8**	**1,394.9**	**-174.9**	**88.9**

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд давхардсан тоогоор 3276.3 мянган иргэн даатгуулсан нь өмнөх оноос 11.8 хувиар, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллага 39.4 мянга болж, өмнөх оноос 16.3 хувиар нэмэгджээ.

Хэдийгээр шимтгэл төлөгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд өмнөх оноос өссөн ч НДС-гийн орлого 174.9 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Тайлант онд НДС-гийн нийт 811.1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөөс 35 гэрээгээр 532.0 тэрбум төгрөгийг арилжааны банкинд байршуулсан нь өмнөх оноос 287.0 тэрбум төгрөгөөр буюу 2.1 дахин өсч, нийт мөнгөн хөрөнгийн 65.6 хувийг эзэлж байна.

2013 онд хадгаламжийн хүүгээс 25.4 тэрбум төгрөгийн орлого оруулж байсан бол 2014 онд 44.4 тэрбум төгрөгт хүрч 19.0 тэрбум төгрөгөөр буюу 74.8 хувиар өссөн байна.

5.2 Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарлага

Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуулиар зарлагыг нийт 1,310.3 тэрбум төгрөгөөр баталсан байна.

2014 онд Нийгмийн даатгалын сангаас давхардсан тоогоор 4,975.8 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалд нийт 1,286.3 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардалд нийт 28.7 тэрбум төгрөгийг тус тус зарцуулжээ. Зардлын гүйцэтгэлийг харуулбал,

/тэрбум төгрөг/

	Ангилал	2014 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгал	973.8	985.5	11.7	101.2
2	Тэтгэмжийн даатгал	73.3	78.5	5.2	107.1
3	ҮОМШӨ-ний даатгал	31.6	29.6	2.0	93.7
4	Ажилгүйдлийн даатгал	16.9	17.8	0.9	105.3
5	Эрүүл мэндийн даатгал	181.2	174.8	6.4	96.5
6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны төлбөр	0.1	0.1	-	100.0
7	Үйл ажиллагааны зардал	20.0	19.4	0.6	97.0
8	Хөрөнгө оруулалт	13.4	9.3	4.1	69.4
	ДҮН	**1,310.3**	**1,315.0**	**4.7**	**100.4**

Сангуудын зардал дараах шалтгаанаар хэтэрсэн байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын сан 11.6 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь “Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцох тухай” хуулийн дагуу 570 орчим мянган хүн нөхөн тооцуулж, мөн халамжийн тэтгэвэр авч байсан 12.7 мянган хүн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах болсон, Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоолоор тэтгэврийн хэмжээг 2014 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлсэнтэй,
- Тэтгэмжийн даатгалын сангийн зардал 5.2 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь төрөх насны эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 45.7-53.0 мянга болж нэмэгдсэн, даатгуулагчдын тэтгэмж бодох дундаж цалин өссөнтэй,
- Ажилгүйдлийн даатгалын сан 0.9 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь эдийн засгийн хүндрэлээс шалтгааж тайлант онд уул уурхайн компаниуд үйл ажиллагаа зогсоож, орон тооны цомхотгол хийснээр ажилгүйдлийн тэтгэмж авах даатгуулагчдын тоо өссөн, мөн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо улсын хэмжээнд 52.3 мянга болж өссөн, даатгуулагчийн ажилгүй болохын өмнөх дундаж цалин өмнөх оныхтой харьцуулахад нэмэгдсэнтэй холбоотой *байна.*

Нийгмийн даатгалын байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалд 20.0 тэрбум төгрөг зарцуулахаас 19.4 тэрбум төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 97.0 хувьтай байна.

2014 онд НДС-гаас хөрөнгө оруулалтад 13.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 9.3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал,

/тэрбум төгрөгөөр/

Тайлант онд Нийгмийн даатгалын байгууллагад хийгдэх хөрөнгө оруулалтад төлөвлөлтөөс 4.3 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ.

Хөрөнгийн зардал	*Төлөв*	*Гүйц*	*Зөрүү*	*Хувь*
Барилга, их засвар	8.3	7.3	-1.1	86.9
Тоног төхөөрөмж	4.2	1.0	-3.2	23.8
Автомашин	0.5	0.5	-	100.0
Тавилга эд хогшил	0.4	0.5	0.1	125.0
Нийт хөрөнгө оруулалт	**13.6**	**9.3**	**-4.3**	**68.4**

5.3 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл

Нийгмийн даатгалын сангийн нийт тэнцэл 259.5 тэрбум төгрөгийн ашигтайгаар төлөвлөж гүйцэтгэлээр 79.8 тэрбум төгрөгийн ашигтай гарч, сангийн харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл нь мөн дүнгээр нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн тайлант оны тэнцлийн ашгийн хэмжээг өмнөх онтой харьцуулахад 145.5 тэрбум төгрөгөөр буурчээ.

БҮЛЭГ 6. Нэмэлт төсвийн гүйцэтгэл

2014 онд нэмэлт төсвөөр 315.6 тэрбум төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн байна.

Нийт эх үүсвэрийн 67.2 хувь буюу 212.2 тэрбум төгрөг нь төсвийн эх үүсвэрээс, 32.8 хувь буюу 103.4 тэрбум төгрөг нь төсвийн бус эх үүсвэрээс бүрджээ. Үүнд:

- *Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 139.7 тэрбум төгрөг,*
- *Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 13.5 тэрбум төгрөг,*
- *Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 77.3 тэрбум төгрөг,*
- *ЗГ-ын болон Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 61.7 тэрбум төгрөг,*
- *УИХ-аас баталсан ЗГ хоорондын гэрээ болон Олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл 12.6 тэрбум төгрөг,*
- *Төсвийн урамшуураас 10.8 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.*

Тайлант онд нэгдсэн төсвийн нэмэлт төсвийн гүйцэтгэлээр 329.6 тэрбум, үүнээс улсын төсөвт 200.4 тэрбум, орон нутгийн төсөвт 129.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Орон нутгийн нэмэлт санхүүжилтийн 46.1 хувь буюу 59.5 тэрбум төгрөгийг татаасын зориулалтаар, 42.3 хувь буюу 54.7 тэрбум төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 5.7 хувь буюу 7.4 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан бол үлдсэн 5.9 хувь буюу 7.6 тэрбум төгрөгийг урсгал шилжүүлэг болон нийгмийн хамгааллын чиглэлээр зарцуулжээ.

Орон нутгийн нэмэлт төсвийн нийт зарцуулалтын 66.3 хувь буюу 85.7 тэрбум төгрөгийг Улаанбаатар хот, 4.0 хувь буюу 5.2 тэрбум төгрөгийг Увс аймаг, 9.0 буюу 11.6 тэрбум төгрөгийг Дорнод, Өвөрхангай, Төв аймгууд, үлдсэн 20.9 хувь буюу 27.0 тэрбум төгрөгийг бусад аймгууд зарцуулсан байна.

БҮЛЭГ 7. Дүгнэлт

Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн орлого, тэнцэл болон өрийн хэмжээ УИХ-аас баталсан Төсвийн хүрээний мэдэгдлийн шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна.

2. Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 6,316.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 716.8 тэрбум төгрөгийн орлого дутуу төвлөрсөн нь эдийн засгийн гадаад орчны нөлөөлөл байгаагаас гадна, татварын орлогын төлөвлөлт, бүрдүүлэлтэд оновчтой тогтолцоо, зохион байгуулалт хангалтгүй, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр ашиг сайжрахгүй байгаа нь нөлөөлж байна.

3. Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 7,640.4 тэрбум төгрөгөөр батлагдаж, 7,144.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.

4. Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 981.0 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 867.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

5. Төсвийн тогтворжуулалтын санд 422.4 тэрбум төгрөг хуримтлагдсан бөгөөд тайлант онд 118.2 тэрбум төгрөгийг зарцуулж, 304.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

6. Монгол Улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн нийт хэмжээ тайлант оны эцэст 11,871.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь ДНБ-ий 54.1 хувьтай тэнцэж байна.

БҮЛЭГ 8. Зөвлөмж

Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

Засгийн газраас ирүүлсэн Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 6,316,522.6 сая төгрөгийн орлого, 7,144,568.0 сая төгрөгийн зарлагыг гүйцэтгэлийн аудитаар баталгаажууллаа.

Монгол Улсын Ерөнхий сайдад зөвлөх нь:

Засгийн газар болон ТЕЗ-дын үйл ажиллагааны хөтөлбөрийн агуулга, бүрэлдэхүүн, хүрэх үр дүн, шаардагдах нөөцийг тодорхойлох, түүнд суурилан төсвийг төлөвлөх, гүйцэтгэлийг тайлагнах нэгдсэн арга зүй, зохион байгуулалтын асуудлыг боловсруулж шийдвэрлэх, тууштай хэрэгжүүлэх.

Хавсралт №3

МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

(сая төгрөг)

Үзүүлэлт	Нэгдсэн төсвийн дүн		Үүнээс:							
			Улсын төсөв		Орон нутгийн төсөв		Хүний хөгжлийн сан		Нийгмийн даатгалын сан	
	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**7 033 291,2**	**6 316 522,6**	**4 770 112,9**	**4 244 274,3**	**2 138 480,0**	**2 092 170,3**	**549 780,0**	**426 957,7**	**1 569 770,5**	**1 394 879,6**
ТОГТВОРЖИЛТИЙН САН	**29 799,6**	**39 913,8**	**29 799,6**	**39 913,8**	-	-	-	-	-	-
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**7 003 491,5**	**6 276 608,8**	**4 740 313,3**	**4 204 360,5**	**2 138 480,0**	**2 092 170,3**	**549 780,0**	**426 957,7**	**1 569 770,5**	**1 394 879,6**
Урсгал орлогын дүн	7 001 314,6	6 274 346,3	4 557 948,6	4 022 699,0	809 272,7	844 077,5	549 780,0	426 957,7	1 249 639,2	1 141 601,2
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	**7 640 397,0**	**7 144 568,0**	**5 631 357,1**	**5 229 168,5**	**2 375 082,5**	**2 129 630,3**	**318 498,0**	**312 490,2**	**1 310 311,8**	**1 315 038,3**
үүнээс: урсгал зарлагын дүн	5 517 216,4	5 293 361,6	4 231 960,6	3 910 233,6	1 670 147,9	1 606 646,1	313 077,7	312 490,2	1 296 882,5	1 305 751,0
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ: *урсгал*	**1 484 098,3**	**980 984,6**	**325 988,0**	**112 465,4**	**(860 875,2)**	**(762 568,6)**	**236 702,3**	**114 467,5**	**(47 243,3)**	**(164 149,8)**
нийт	**(636 905,5)**	**(867 959,1)**	**(891 043,7)**	**(1 024 808,0)**	**(236 602,5)**	**(37 460,1)**	**231 282,0**	**114 467,5**	**259 458,7**	**79 841,4**
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР	**636 905,5**	**867 959,1**	**891 043,7**	**1 024 808,0**	**236 602,5**	**37 460,1**	**(231 282,0)**	**(114 467,5)**	**(259 458,7)**	**(79 841,4)**
1. Хөрөнгө болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(203 122,4)	144 034,6	37 657,6	235 349,5	229 294,1	21 583,6	(210 615,4)	(33 057,2)	(259 458,7)	(79 841,4)
2. Засгийн газрын бонд	1 073 160,2	1 050 847,8	855 160,2	836 036,8	-	-	218 000,0	214 811,0	-	-
2.1. Урт хугацаат	1 073 160,2	1 051 821,4	855 160,2	837 010,4	-	-	218 000,0	214 811,0	-	-
2.1.1. Дотоод шинээр гаргах	2 793 160,2	2 579 728,0	2 255 160,2	2 095 106,1	-	-	538 000,0	484 621,9	-	-
2.1.2. үндсэн төлбөр	(646 839,8)	(476 085,2)	(544 839,8)	(421 085,2)	-	-	(102 000,0)	(55 000,0)	-	-
2.1. Богино хугацаат	-	(973,6)	-	(973,6)	-	-	-	-	-	-
2.1.1. Дотоод шинээр гаргах	897 000,0	897 900,3	897 000,0	896 926,7	-	-	-	-	-	-
2.1.2. үндсэн төлбөр	(897 000,0)	(898 873,9)	(897 000,0)	(898 873,9)	-	-	-	-	-	-
3. Засгийн газрын зээл	1 994,6	142 650,6	(5 313,8)	126 774,1	7 308,4	15 876,5	-	-	-	-
3.1. Дотоод	(112 567,7)	(109 945,8)	(112 567,7)	(109 945,8)	-	-	-	-	-	-
3.1.1. Монгол банк (ОУВС)	(112 567,7)	(109 945,8)	(112 567,7)	(109 945,8)	-	-	-	-	-	-
3.1.1.1 Шинээр гаргах	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.1.1. 2 Үндсэн төлбөр	(112 567,7)	(109 945,8)	(112 567,7)	(109 945,8)	-	-	-	-	-	-
3.2. Гадаад	114 562,3	252 596,5	107 253,9	236 720,0	7 308,4	15 876,5	-	-	-	-
3.2.1. Төслийн зээл	114 562,3	252 596,5	107 253,9	236 720,0	7 308,4	15 876,5	-	-	-	-
3.2.1.1. Шинээр авах	267 229,5	369 029,5	259 921,1	353 153,0	7 308,4	15 876,5	-	-	-	-
3.2.1.2. Үндсэн төлбөр	(152 667,2)	(116 433,1)	(152 667,2)	(116 433,1)	-	-	-	-	-	-
Урьдчилгаа орлогоос орлогод тооцогдсон	(545 988,2)	(642 926,3)	(212 714,7)	(173 352,5)	-	-	(333 273,5)	(469 573,8)	-	-

Хавсралт №2

МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

(сая төгрөг)

Үзүүлэлт	Зарлагын нэгдсэн дүн			Үүнээс:											
				Улсын төсөв			Орон нутгийн төсөв			Хүний хөгжил сан			нийгмийн даатгалын сан		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	**7 640 397,0**	**7 144 568,0**	**495 829,1**	**5 631 357,1**	**5 229 168,5**	**402 188,6**	**2 375 082,5**	**2 129 630,3**	**245 452,2**	**318 498,0**	**312 490,2**	**6 007,8**	**1 310 311,8**	**1 315 038,3**	**(4 726,5)**
А. УРСГАЛ ЗАРЛАГА	**5 517 216,4**	**5 293 361,6**	**223 854,7**	**4 231 960,6**	**3 910 233,6**	**321 727,0**	**1 670 147,9**	**1 606 646,1**	**63 501,8**	**313 077,7**	**312 490,2**	**587,5**	**1 296 882,5**	**1 305 751,0**	**(8 868,5)**
1. Бараа, үйлчилгээний зардал	2 806 334,6	2 652 480,8	153 853,8	1 643 493,6	1 536 021,5	107 472,0	1 296 944,6	1 246 867,8	50 076,8	-	-	-	19 186,7	18 547,4	639,3
1.1 Цалин, хөлс	1 615 888,0	1 586 419,5	29 468,5	889 265,4	866 078,0	23 187,4	713 553,3	707 427,6	6 125,7	-	-	-	13 069,3	12 913,9	155,4
1.2 Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	153 290,3	148 955,9	4 334,4	71 711,7	68 766,1	2 945,6	79 041,6	77 881,2	1 160,4	-	-	-	2 537,0	2 308,6	228,4
1.3 Бараа, үйлчилгээний бусад зардал	1 190 446,6	1 066 061,3	124 385,2	682 516,4	601 177,4	81 339,0	504 349,6	461 559,0	42 790,7	-	-	-	3 580,5	3 325,0	255,5
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	509 139,6	500 351,2	8 788,4	447 095,1	438 326,3	8 768,8	-	-	-	62 044,5	62 024,9	19,6	-	-	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	2 201 742,2	2 140 529,6	61 212,6	2 141 372,0	1 935 885,8	205 486,1	373 203,3	359 778,3	13 425,0	251 033,2	250 465,3	567,9	1 277 695,7	1 287 203,6	(9 507,8)
3.1 Татаас	188 897,4	167 195,4	21 702,0	491 071,0	403 995,4	87 075,6	4 886,4	4 846,1	40,3	-	-	-	142 707,0	140 543,4	2 163,6
3.2 Урсгал шилжүүлэг	2 012 844,8	1 973 334,2	39 510,6	1 650 301,0	1 531 890,4	118 410,5	368 316,9	354 932,2	13 384,8	251 033,2	250 465,3	567,9	1 134 988,8	1 146 660,2	(11 671,4)
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	**2 123 716,1**	**1 771 069,2**	**352 646,9**	**1 399 931,9**	**1 238 797,7**	**161 134,2**	**704 934,6**	**522 984,3**	**181 950,4**	**5 420,3**	**-**	**5 420,3**	**13 429,3**	**9 287,3**	**4 142,0**
1. Хөренгө оруулалт	1 779 789,1	1 399 662,8	380 126,3	1 132 327,8	923 523,6	208 804,2	628 611,7	466 851,9	161 759,7	5 420,3	-	5 420,3	13 429,3	9 287,3	4 142,0
2. Их засвар	104 110,4	87 299,4	16 811,0	48 620,1	46 005,6	2 614,5	55 490,3	41 293,8	14 196,5	-	-	-	-	-	-
3. Хөренгийн бусад зардал	43 647,9	31 001,4	12 646,5	43 616,6	30 940,4	12 676,2	31,3	61,0	(29,7)	-	-	-	-	-	-
4.Төслийн зээлээр санхүүжих хөренгийн зардал	196 168,7	253 105,6	(56 936,9)	175 367,3	238 328,1	(62 960,7)	20 801,4	14 777,5	6 023,8	-	-	-	-	-	-
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	**-535,4**	**80 137,1**	**(80 672,5)**	**-535,4**	**80 137,1**	**(80 672,5)**	-	-	-	-	-	-	-	-	-
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-48 860,5	10 715,4	(59 575,9)	-48 860,5	10 715,4	(59 575,9)	-	-	-	-	-	-	-	-	-
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	48 325,1	69 421,7	(21 096,6)	48 325,1	69 421,7	(21 096,6)	-	-	-	-	-	-	-	-	-

Хавсралт №3

МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

(сая төгрөг)

Үзүүлэлт	Нэгдсэн төсвийн дүн		Үүнээс:							
			Улсын төсөв		Орон нутгийн төсөв		Хүний хөгжлийн сан		Нийгмийн даатгалын сан	
	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**7 033 291,2**	**6 316 522,6**	**4 770 112,9**	**4 244 274,3**	**2 138 480,0**	**2 092 170,3**	**549 780,0**	**426 957,7**	**1 569 770,5**	**1 394 879,6**
ТОГТВОРЖИЛТИЙН САН	**29 799,6**	**39 913,8**	**29 799,6**	**39 913,8**	-	-	-	-	-	-
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**7 003 491,5**	**6 276 608,8**	**4 740 313,3**	**4 204 360,5**	**2 138 480,0**	**2 092 170,3**	**549 780,0**	**426 957,7**	**1 569 770,5**	**1 394 879,6**
Урсгал орлогын дүн	7 001 314,6	6 274 346,3	4 557 948,6	4 022 699,0	809 272,7	844 077,5	549 780,0	426 957,7	1 249 639,2	1 141 601,2
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	**7 640 397,0**	**7 144 568,0**	**5 631 357,1**	**5 229 168,5**	**2 375 082,5**	**2 129 630,3**	**318 498,0**	**312 490,2**	**1 310 311,8**	**1 315 038,3**
үүнээс: урсгал зарлагын дүн	5 517 216,4	5 293 361,6	4 231 960,6	3 910 233,6	1 670 147,9	1 606 646,1	313 077,7	312 490,2	1 296 882,5	1 305 751,0
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ: *урсгал*	**1 484 098,3**	**980 984,6**	**325 988,0**	**112 465,4**	**(860 875,2)**	**(762 568,6)**	**236 702,3**	**114 467,5**	**(47 243,3)**	**(164 149,8)**
нийт	**(636 905,5)**	**(867 959,1)**	**(891 043,7)**	**(1 024 808,0)**	**(236 602,5)**	**(37 460,1)**	**231 282,0**	**114 467,5**	**259 458,7**	**79 841,4**
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР	**636 905,5**	**867 959,1**	**891 043,7**	**1 024 808,0**	**236 602,5**	**37 460,1**	**(231 282,0)**	**(114 467,5)**	**(259 458,7)**	**(79 841,4)**
1. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(203 122,4)	144 034,6	37 657,6	235 349,5	229 294,1	21 583,6	(210 615,4)	(33 057,2)	(259 458,7)	(79 841,4)
2. Засгийн газрын бонд	1 073 160,2	1 050 847,8	855 160,2	836 036,8	-	-	218 000,0	214 811,0	-	-
2.1. Урт хугацаат	1 073 160,2	1 051 821,4	855 160,2	837 010,4	-	-	218 000,0	214 811,0	-	-
2.1.1. Дотоод шинээр гаргах	2 793 160,2	2 579 728,0	2 255 160,2	2 095 106,1	-	-	538 000,0	484 621,9	-	-
2.1.2. үндсэн төлбөр	(646 839,8)	(476 085,2)	(544 839,8)	(421 085,2)	-	-	(102 000,0)	(55 000,0)	-	-
2.1. Богино хугацаат	-	(973,6)	-	(973,6)	-	-	-	-	-	-
2.1.1. Дотоод шинээр гаргах	897 000,0	897 900,3	897 000,0	896 926,7	-	-	-	-	-	-
2.1.2. үндсэн төлбөр	(897 000,0)	(898 873,9)	(897 000,0)	(898 873,9)	-	-	-	-	-	-
3. Засгийн газрын зээл	1 994,6	142 650,6	(5 313,8)	126 774,1	7 308,4	15 876,5	-	-	-	-
3.1. Дотоод	(112 567,7)	(109 945,8)	(112 567,7)	(109 945,8)	-	-	-	-	-	-
3.1.1. Монгол банк (ОУВС)	(112 567,7)	(109 945,8)	(112 567,7)	(109 945,8)	-	-	-	-	-	-
3.1.1.1 Шинээр гаргах	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.1.1. 2 Үндсэн төлбөр	(112 567,7)	(109 945,8)	(112 567,7)	(109 945,8)	-	-	-	-	-	-
3.2. Гадаад	114 562,3	252 596,5	107 253,9	236 720,0	7 308,4	15 876,5	-	-	-	-
3.2.1. Төслийн зээл	114 562,3	252 596,5	107 253,9	236 720,0	7 308,4	15 876,5	-	-	-	-
3.2.1.1. Шинээр авах	267 229,5	369 029,5	259 921,1	353 153,0	7 308,4	15 876,5	-	-	-	-
3.2.1.2. Үндсэн төлбөр	(152 667,2)	(116 433,1)	(152 667,2)	(116 433,1)	-	-	-	-	-	-
Урьдчилгаа орлогоос орлогод тооцогдсон	(545 988,2)	(642 926,3)	(212 714,7)	(173 352,5)	-	-	(333 273,5)	(469 573,8)	-	-

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2015 оны 6 сарын 9 өдөр Дугаар 153 Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2016 оны 5 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд нарт зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэлийн аудитын газрын дарга М.Наранжаргалд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР А.ЗАНГАД